



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ  
2009 оны 07 сарын 16 өдөр

ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ  
ЭХ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН  
ХАМГААЛАЛТЫН БУС, ОЙН САН  
БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох, тухайн газарт байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий**

газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал

хайх, ашиглахыг хориглох тухай хууль тогтоомж

2.1. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль тогтоомж нь Монгол Улсын үндсэн хууль [\[1\]](#), үндэсний аюулгүй байдлын тухай [\[2\]](#), Байгаль орчныг хамгаалах тухай [\[3\]](#), Усны тухай [\[4\]](#), Ойн тухай [\[5\]](#), Ашигт малтмалын тухай хууль [\[6\]](#), энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“гол, мөрний урсац бүрэлдэх эх” гэж гадаргын урсацын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бус, сав газрын эхийг;

3.1.2.“ойн сан бүхий газар” гэж Ойн тухай хуулийн 3.1.2-т заасныг;

3.1.3.“усны сан бүхий газрын хамгаалалтын бус” гэж Усны тухай хуулийн 31.3-т заасныг.

**4 дүгээр зүйл. Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох**

4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.

4.2. Энэ хуулийн 4.1 дэх хэсэг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй.

4.3. Энэ хуулийн 4.1-д заасан газрын хилийн заагийг Засгийн газар тогтооно.

4.4.Энэ хуулийн 4.3-т заасан хилийн заагийн гадна үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хөрөнгөөр байгаль орчны нөхөн сэргээлт хийж, таримал ой, хиймэл нуур, усан сан байгуулсан бол энэхүү хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

4.5.Энэ хуулийн 4.1-д заасан газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.

4.6.Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахдаа уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн олговор төлөх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар тогтооно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ БАЙГАЛЬ ОРЧНЫГ НӨХӨН СЭРГЭЭХ АЖИЛЛАГАА**

### **5 дугаар зүйл. Байгаль орчныг нөхөн сэргээх**

5.1.Энэ хуулийн 4.6-д заасны дагуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийг байгаль орчныг нөхөн сэргээх үүргээс чөлөөлөхгүй.

5.2.Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орон нутгийн удирдлага болон нутгийн иргэдийн олон нийтийн хяналт дор 2 хүртэл жилийн хугацаанд хийж дуусгана.

5.3. Энэ хуулийн 5.2-т заасан олон нийтийн хяналтыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээс байгаль орчныг хамгаалах зорилго, чиглэл бүхий төрийн бус байгууллагуудад гэрээний үндсэн дээр хариуцуулж болно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД**

### **6 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

6.1.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд зөрчлийн шинж байдлыг харгалzan Эрүүгийн хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

### **6 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

6.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулахаар заасан бөгөөд үүнийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

[1] Монгол Улсын Індсэн хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

[2] Үндэсний аюулгүй байдлын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

[3] Байгаль орчныг хамгаалах тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

[4] Усны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2004 оны 18 дугаарт нийтлэгдсэн.

[5] Ойн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2007 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

[\[6\]](#) Ашигт малтмалын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2006 оны 30 дугаарт нийтлэгдсэн.